# Нийтийн хоолны газруудын сонгодог үйлчилгээ

Нийтийн хоолны газрууд нь хөдөлмөрчдийн чөлөөт цагийг уртасгаж гэр ахуйдаа ажиллах, сурахад нь ашигтай цаг ямагт олгож байдгаараа үйлчлүүлэгчдэд хамгийн ойр дотно үйлчилгээний нэг билээ.

Ер нь нийтийн хоолны газрууд үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа гурвыг хослон явуулдгаараа онцлогтой юм. Нийтийн хоолны газруудын ашигт ажиллагааг хангах тэнд ажиллагсадын хөдөлмөрийг хөнгөвчлөх талаар манай нам засгаас байнга анхаарч ирсний үр дүнд нийтийн хоолны газруудын ажиллагаа өдрөөс өдөрт хөнгөрч орчин үеийн цахилгаан тоног төхөөрөмжөөр хангагдсаар байна.

Үүнээс гадна үйлчилгээний зохистой хэлбэрүүд нэвтэрсээр байна.

Нийтийн хоолны газруудын сонгомол үйлчилгээнд өөрөө өөртөө үйлчлэх арга, комплектолсон үдийн хоолоор үйлчлэх арга, урьдчилан талон худалдаалан үйлчлэх арга, хоёрдмол үйлчилгээ, кофе үйлчилгээ зэргүүд ордог.

### Өөрөө өөртөө үйлчлэх

Өөрөө өөртөө үйлчлэх арга манайд хамгийн өргөн дэлгэр нэвтэрч байгаа үйлчилгээний нэг билээ. Энэ үйлчилгээ нь үйлчлэгч үйлчлүүлэгч нарын аль алинаас нь хамгийн соёлч байдлыг шаарддаг юм.

Үйлчлүүлэгч хүн ормогц хоолны нэрсийн жагсаалтаас идэх хоолоо сонгосны дараа урьдаас бэлтгэсэн цэвэр халбага, сэрээ, хутга зэргээс аль шаардлагатай зүйлийг авч хоол олгогчоор хоолоо тавагluулж суухаас өмнө хоолоо үзүүлэн мөнгө хураагчаас талон авна.

Хоолоо идэж дууссаны дараа гарахдаа талоныг хураалгаж аяга тавгаа угаагчид өгнө.

Ингэж үйлчлүүлэхэд хамгийн цэвэрч нямбай хандахаас гадна үйлчилгээний дэс дараалал, ёс гурмыг нарийн сайн мэдсэн байх хэрэгтэй.

Өөрөө өөртөө үйлчлэх гуанзны дотоод зохион байгуулалт маш зөв хийгдсэн байвал зохино.

### Компектолсон үдийн хоол

Комплектолсон үдийн хоолоор үйлчлэх үйлчилгээ нь манайд төдийлөн их нэвтэрч чадаагүй байгаа үйлчилгээний нэг юм.

Энэ үйлчилгээ нь хүмүүсийг зөв хооллоход ихээхэн ашиг тусыг өгөхөөс гадна үйлчилгээний чирэгдлийг багасгаж, мөнгө хураагчийн ажлыг 3-4 дахин хөнгөлдөг юм.

Комплектолсон үдийн хоол нь янз бүрийн нөхцөл байдалд ажилладаг хүмүүс,ажлын байдалд зохицуулан шинжлэх ухааны үндэстэйгээр хооллож цаашдаа ажиллах, ихийг бүтээх үндсийг тавьж өгдөгөөрөө асар их ач холбогдолтой.

Энэ үйлчилгээ нь хүмүүс биедээ тохирсон хоолыг сонгож авахад нь тусалахаас гадна мөнгө хураагчийн өмнө өдий төдий хоолны нэр тоочин очерлож цаг алдахаас чөлөөлнө. Комплектолсон хоолыг ямар ч үнэтэйгээр тогтоож болох ба харин тэгэхдээ нэгж мөнгөний үлдэгдэлгүйгээр тохируулбал зохино.

Комплектолсон үдийн хоол нь нэгж минутад үйлчлүүлэх хүний тоог нэмэгдүүлж гүйлгээний эргэлтийг хурдасгадаг юм.

### Урьдчилсан талон худалдаалах

Энэ үйлчилгээ нь манайд бас л төдийлөн их дэлгэрээгүй гэхэд болно.

Харин энэ үйлчилгээ нилээд нягт нямбай ажиллагааг шаардахад хүрнэ.

Уг үйлчилгээгээр тогтмол үйлчлүүлэгчдэд үйлчлэхэд нэн тохиромжтой.

Энэ нь сар бүрийн эхэнд тэр сард тус гуанзнаас хооллогчдод талоныг урьдчилан худалдаалчихаад шаардлагатай үед хоолло но гэсэн үг юм.

Энэ нь үйлчилгээг асар их хөнгөлж хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ.

Ингэснээрээ улсын төлөвлөгөөг биелүүлэх нэгэн нөхцлийг бүрэлдүүлдэг юм.

### Цуваа графикаар үйлчлэх

Хоёрдмол үйлчилгээг 60 аас дээш хүний суудалтай цуваа графикаар буюу 2 ээлжээр ажилладаг гуанзуудад явуулж болно.

Энэ нь өдрийн цагаар гуанз, оройн цагаар ресторoны үйлчилгээ явуулна гэсэн үг юм.

Энэ үйлчилгээний гол ашиг тус нь хүмүүсийг зөв зохистой амрахад нь туслана.

Ер нь цуваа графикаар үйлчлэх явдал бас л сонгомол үйлчилгээний нэг юм.

### Кофе үйлчилгээ

Кофе үйлчилгээг өргөн дэлгэр явуулах явдал хөдөлмөрчдийн амралтанд ихээхэн ашиг тус өгөх юм.

Нийтийн хоолны газруудад одоогоор сонгомол гэж байгаа эдгээр үйлчилгээнээс гадна манай нөхцөлд тохирох үйлчилгээний дэвшилттэй хэлбэрүүд олон байдаг.

Үүнд цуваа графикаар ажиллах, өрөөлдүү графикаар ажиллах, фабрик гал зуух, гуанз дундын үйлдвэрлэлтэй болох зэрэг чухал үйлчилгээний хэлбэрүүд байдаг.

Иймээс манай аймгийн төв хөдөөгийн гуанзнууд үйлчилгээний дээрх арга хэлбэрийг бололцоо нөхцөлдөө тохируулан өөрсдийн ажиллагаандаа нэвтрүүлэх нь чухал байна.

**Д. Ренчиндорж**

# Нийт хүн ам, орон сууцны фондын тооллогот бэлтгэе

Социалист нийгмийн үндсэн зорилго болсон хүн ардынхаа соёлч боловсон байдал чинээлэг амьдралыг дүүрэн хангахад манай нам,төрийн байгууллагын удирдамж шийдвэр ямагт чиглэгдэж байдаг.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс нийт хүн ам, орон сууцны фондын тооллого явуулах тухай гаргасан шийдвэрийг биелүүлэхээр аймгийн АДХГ Захиргаа авч хэлэлцээд «Нийт хүн ам,орон сууцны фондын тооллогын бэлтгэлийг бүрэн хангаж зохион байгуулалттай,үнэн зөв явуулах нь тус аймгийн улс, олон нийт, аж ахуйн байгууллагын өмнө тавигдаж байгаа улс төр, эдийн засгийн ээлжит чухал зорилт мөн» гэж тэмдэглэсэн байна.

1968 оны 12 дугаар сарын 15-наас 19-нд мал тооллогын хамт улс, олон нийт, аж ахуйн байгууллагын бүх орон сууц, 1969 оны 1 дүгээр сарын 10-наас 14-нд нийт хүн ам, амины бүх орон сууц нэгэн зэрэг тоологдоно.

Нийт хүн амын тооллогыг шинжлэх ухааны үндэслэл, амьдралын баталгаатай явуулж дүгнэх нь ард түмний соёл, амьдралын түвшинг тодорхойлж хэтийн болон жилийн төлөвлөгөөнд шаардагдах асуудлыг үнэн зөв тусган илэрхийлэх чухал ач холбогдолтой юм.

Хүн амын тооллого нь иргэн нэг бүрээс асуух журмаар явагдах учир өөрийн болон асрамж хамгаалалдаа байдаг хүмүүсийг үнэн зөв бүртгүүлэх асуудлыг нийт хөдөлмөрчид анхааран, тооллогын хуудасны асуулт бүхнийг судлан ойлгосон байх хэрэгтэй.

Улс хоршооллын болон амины бүх орон сууцны фондыг тоолсноор ард түмний ахуй амьдралын нэг гол нөхцлийг улсаас судлан дүгнэж, цаашдын зорилтыг тодорхойлох учир улс, олон нийт, аж ахуйн бүх байгууллага өөрийн орон сууц бүхнийг засаж сэлбэх ашиглалтыг сайжруулахад анхаарч нарийн хэмжин үндсэн хөрөнгийн карттай тохируулан шалгаж, данс бүртгэлээч цэгцэлсэн байх хэрэгтэй. Амины орон сууц (гэр байшин) тоологдох, мөн нийт хүн амын тооллогын хамт орон сууцны байдал, төрөл тохижилтыг судлан бүртгэнэ.

Энэ тооллого нь манай орны эдийн засгийн хөгжлийн хурдац ард түмний аж байдлын дээшлэлтийг зөв тусган цаашдын зорилтыг төлөвлөх үндэс нь болох хариуцлагатай асуудал учир орон нутгийн бүх байгууллага, ард түмний өмнө ихээхэн хөдөлмөр санаачлага шаардсан өргөн компанит ажил мөн.

Хот, сум хороодын АДХГ Захиргаад тооллогын ажил хариуцан удирдах комисс, бүх материалыг шалган хүлээж авах, мэдээлэх, урьдчилан дүн гаргах товчоодыг дадлага мэргэжилтэй хүмүүсийг оролцуулан байгуулах, мөн тооллогын хэсгүүд байгуулж тоологчдоор хөдөлмөрчдийн дотор нэр хүндтэй бичгийн чадвартай хүмүүсийг томилох хэрэгтэй.

Тооллогын заавар, асуултыг бүх хөдөлмөрчдөд ойлгуулж тооллогын ажил хариуцагчдад тодорхой семинар өгч, дадлагын ажлыг сайн хийх нь чухал юм.

Хүн ам, орон сууцны фондын тооллогын техник ажлын хэмжээг 1963 оны хүн амын тооллоготой харьцуулан жишвэл дахин илүү хөдөлмөр шаардагдах жилийн эцсийн мал ба хөрөнгийн тооллого аж ахуй, соёлын 1968 оны төлөвлөгөөний биелэлт гаргах зэрэг эдийн засаг, санхүү, бүртгэлийн томоохон ажлууд зэрэгцэн зохиогдох учир орон нутгийн нам, улс, олон нийт, аж ахуйн байгууллагууд хүмүүсийн хүчийг нарийн төлөвлөгөөтэй хувиарлан зохицуулах шаардлагатай байна.

Хот, сум, хороо, бүхэн харъяалсан бүх нутагтаа тооллогыг бүрэн хариуцах учир хөдөлмөрчдийн суурьшлын байдалд нь тохируулан засаг захиргааны харъяаллыг ойрын хугацаанд шийдвэрлэх хэрэгтэй байна.

Ард түмний амин чухал асуудлыг дэвшүүлэн, нийт хүн ам, орон сууцны фондын тооллого явуулах талаар гаргасан БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл, аймгийн АДХГ Захиргааны тогтоолыг хэрэгжүүлэн, шинжлэх ухааны үндэслэл амьдралын бодит баталгаатай үр дүн гарахад манай аймгийн бүх ажилтан, ажилчид, хоршоологчид, нийт хөдөлмөрчид оюун санаа, хүч чадлаа дайчлан ажиллаж, тавигдаж байгаа зорилтыг амжилттай шийдвэрлэх нь дамжиггүй.

**Ө. Хаянхярваа**

## Таны сонирхолд

* Английн физикч Томас Юнг 2 настайдаа уншиж сураад 6 настайдаа геометрийн судлалтай танилцаж эхэлсэн байна. 14 насандаа Франц, Итали, Эртний Еврей, Перс, Араб хэлнүүдийг мэддэг байсан аж.

Т. Юнг 22 насандаа анагаах ухааны факультет төгссөн ба 27 настайдаа физикийн профессор болсон бөгөөд Египетийн дүрс бичгийг тайлбарлан уншсан байна. Юнг нь бүх төрлийн хөгжмийг эзэмшиж чаддаг ба зураг урлалыг судлан шүүмжилдэг байсан учир түүнийг томоохон шүүмжлэгчийн нэгэнд тооцдог байжээ. Юнг нь оптик, акустик (дуу ухааны судлал), термодинамик, онгоцны үйлдвэр, астроном, геофизик, физиологи, анагаах ухаан, амьтан судлал, лингвистик (хэлний шинжлэл) зэргээр хичээллэж байжээ. Бас эрдэмтэн Юнг, утсан дээгүүр явах, жонглёр тоглох зэрэг циркийн зарим тоглолтыг гарамгай хийдэг байсан гэнэ.

* Немцийн математикч Дириале олон үгэнд тун дургүй хүн байжээ.

Тэрээр өөрийндөө хүү төрсөнтэй холбогдуулж хадамдаа явуулсан цахилгаан нь түүхэнд хамгийн товчхон нь юм.

Уул цахилгаан нь ердөө л 2+1=3 гэсэн байжээ.

* Польшийн эмч нар цэцгийн тарилгыг өвтгөлгүй хийх аргыг сүвэгчлэн, гар буу маягийн шинэ шприц хийжээ.

Вакциныг хурдан бөгөөд өвтгөлгүйгээр арьсны дор нь «буудчихана» буудуулсан хүүхэд айхгүй, инээмсэглээд л үлдэнэ.

**Д. Отгон**

Хариуцлагатай эрхлэгч Н.МӨНХӨӨ

(X—000278) «Анхдугаар таван жил» сонины үйлдвэрт хэвлэв

Орон бүхний пролетари нар нэгдэгтүн.

# Дөрөвдүгээр ТАВАН ЖИЛ

Төв аймгийн намын хороо, АДХ Гүйцэтгэх захиргааны сонин.

21 дэх жилдээ
№ 84 (1773)

1968 ОНЫ
11 ДҮГЭЭР САРЫН 11

ДАВАА

## Монголын хувьсгалт хэвлэл

Монголын хөдөлмөрчин ард түмнийг империализм, феодализмын дарлалаас ангижруулах, тэднийг хувьсгалт тэмцэлд нэгтгэн монголд ардын засаг төрийг үүсгэн байгуулах, Монголын ардын намын үйл хэрэгт манай анхны хувьсгалт хэвлэл «Монголын үнэн» сонин чухал үүрэг гүйцэтгэв.

В.И. Ленин «Зөвхөн, улс төрийн сонин л олон түмнийг жинхэнэ улс төрийн ухамсартай болгон хүмүүжүүлж, манай бүх нийгмийн амьдралыг гэрэлтүүлэн гаргаж чадна» гэсэн гайхамшигт сургаалыг амьдралд хэрэгжүүлэн биелүүлж чадсан сонин бол манай намын анхны энэ сонин билээ.

«Монголын үнэн» сонин, монголын хувьсгалчид, дэлхий дахины ажилчны хөдөлгөөний удирдах төв, олон улсын хувьсгалт байгууллага, коминтерн ба анхны социалист Зөвлөлт улстай холбоо тогтоосон явдал олон орны ажилчин ангийн тэмцлийн туршлагаас сурах, ялсан орны пролетари нараас тусламж авах, манай малчин ардын намыг марксист ленинч сургаал баримталсан монголын хөдөлмөрчин ардын дайчин манлай жинхэнэ хувьсгалт нам болгож өсгөхөд үлэмжийн тус дөхөм үзүүлсэн байна.

Манай нам ардын төрийг үүсгэн байгуулагч их жолоодогч Д. Сүхбаатар хань нөхдийнхөө хамт Эрхүү хотноо 1920 оны сүүлчээр очиж, коминтерны дорно зүгийн олон улсын салбарын Монгол Төвдийн хэлтсийн нөхөдтэй хамтран «Монголын үнэн» гэдэг улс төрийн сонины анхны дугаар 1920 оны 11 дүгээр сарын 10-нд хэвлэгдэн гарсанаас хойш 48 жил болж байна.

Энэ сонин бичиг марксизм-ленинизмын үзэл санаа, Октябрийн их хувьсгалын чөлөөлөгч үзэл санааг Монголын ард түмэнд сурталчлан, ардын хувьсгалд бэлтгэх цогт уриа, дайчин зэвсэг болсон юм.

Монголын хувьсгалт хэвлэл бол МАХН—ын алдарт түүх, империализм ба феодализмыг эсэргүүцэж өрнүүлсэн монгол ардын хувьсгалын түүхтэй салшгүй холбоотой бөгөөд намын үзэл суртлын мохошгүй зэвсэг байх үүргээ нэр төртэй биелүүлж, социалист шинэ нийгмийг цэцэглүүлэн хөгжүүлэх, социализмын үеийн шинэ хүмүүсийг төрүүлэн бойжуулж хүмүүжүүлэх хэрэгт асар их үүрэг гүйцэтгэжээ.

Хувьсгалт хэвлэл нь нам ард түмнээс эх орныхоо эрх чөлөөний төлөө хийсэн баатарлаг тулалдаан, ангийн дайсны эсрэг тэмцсэн ширүүн тэмцэл, улс эх орондоо шинэ эдийн засаг, соёлыг бүрэлдүүлэн тогтоож хөгжүүлэхийн төлөө тус оронд социализмын материал техникийн баазыг байгуулах тэмцэлд залуу үеийг хүмүүжүүлэхэд яруу алдарт намынхаа дайчин зэвсэг, хөдөлмөрчдийн дайчин индэр болж өөрийнхөө үүргийг нэр төртэй биелүүлж байна.

МАХН, өөрийн үзэл суртлын мохошгүй хурц зэвсэг, сонин хэвлэлийг улам хөгжүүлэх дайчин давшингуй байлгах талаар цаг ямагт анхаарсаар ирлээ.

Одоо манай оронд 60 гаруй сонин сэтгүүл нэг удаа сая 200 мянган хувь хэвлэгдэж жилдээ олон зуун нэр төрлийн ном товхимол олон сая хувиар хэвлэгдэх болов. Манай нам засгаас сонин хэвлэлийг мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, хэвлэлийн техник төхөөрөмжийг боловсронгуй болгох, сонин хэвлэлийн үзэл суртал зохион байгуулалтыг сайжруулах талаар ихээхэн анхаарал тавьж ажилласны үр дүнд хэвлэлийн ажилтны бүхэл бүтэн арми бий болж мэргэжилтэй боловсон хүчнээр тухай бүр хангагдаж байна.

Ажилчин малчны сурвалжлагч идэвхтнүүд сонин хэвлэлд идэвхтэй оролцож байгаа нь манай хэвлэлийн жинхэнэ ардач нийтэч чанарыг яруу тод харуулж байгаагаар үл барам, социалист нийгмийн ардчиллыг тодорхойлж байгаа нэг том баримт мөн.

Манай орны сонин хэвлэл радиогийн ажилд одоо 15 мянга орчим идэвхтэн оролцож, чухам тэдний оролцоо, туслалцаанд түшиглэн хэвлэл радиогийн газрууд амжилттай ажиллаж байна.

БНМАУ-д социалист нийгэм байгуулж дуусгах өнөөгийн түүхэн үед манай сонин хэвлэлийн гол зорилт нь МАХН-ын программ, намын XV их хурлын түүхт шийдвэр, тус улсын улс ардын аж ахуй, соёлын газар, нам төр, олон нийтийн байгууллагын үйл ажиллагаа, ажилчин, нэгдэлчин, сэхээтний өдөр дутмын амьдрал, хөдөлмөртэй нягт холбож оновчтой бөгөөд ажил хэрэгчээр сурталчлахад гол анхаарлаа чиглүүлэх ёстой. Тэгэхдээ манай хөдөлмөрчдөөс улс ардын аж ахуй, соёлын төлөвлөгөөт зорилтыг биелүүлэхийн төлөө өрнүүлж байгаа социалист уралдаан, социалист хөдөлмөрийн төлөө хөдөлгөөний эдийн засаг улс төр, үзэл суртал, зан суртахууны ач холбогдлыг тодорхой тооцоо судалгааны үндсэн дээр өргөн сурталчлаж, хүн амын ерөнхий боловсролыг дээшлүүлэхэд анхаарахын хамт хөдөлмөрчдийн ертөнцийг үзэх марксист-ленинист үзлийн мэдлэгийг ойлгомжтой хэлбэрээр сурталчлаж ялангуяа залуу үеийг социалист эх оронч интернационалч үзэл санаа, нам, ард түмний хувьсгалч дайчин хөдөлмөрч уламжлалаар хүмүүжүүлэх нь манай хэвлэлийн одоогийн чухал зорилт мөн.

## Аймгийн Намын Хороонд

Саяхан аймгийн Намын Хорооны Товчоо «Аймгийн Намын Хорооны бүгд хурлыг хуралдуулах тухай» хэлэлцэж, аймгийн Намын Хорооны II бүгд хурлыг 1968 оны 11 дүгээр сарын 28-нд хуралдуулж, «Намын байгууллагаас боловсон хүчинтэй ажиллах ажлыг сайжруулъя» гэсэн асуудал хэлэлцүүлэхээр тогтоов.

## АДХГ Захиргаанд

Аймгийн АДХГ Захиргаа аймгийн АДХ-ын ээлжит чуулган хуралдуулах тухай хэлэлцээд аймгийн АДХ—ын 8 дахь удаагийн сонгуулийн 4 дүгээр чуулганыг 1968 оны 11 дүгээр сарын 29—нд Зуун мод хотод хуралдуулж, «Хөдөлмөрчдийн боловсролын байдал, цаашид авах арга хэмжээний тухай», «Аймгийн АДХ-ын соёл гэгээрлийн байнгын комиссын хавсралт илтгэл», «Эрүүлийг хамгаалах байнгын комиссын тайлан илтгэл»-үүдийг тус тус хэлэлцүүлэхээр тогтоожээ.

Чуулган угтаж хөдөлмөрчдийн боловсролыг дээшлүүлэх ажлын төлөвлөгөөг биелүүлэх, төв суурин газар, айл өрхүүдийн соёлжилт, төрөл бүрийн үйлчилгээг сайжруулахыг сум хороодын АДХГ Захиргаад, албан үйлдвэрийн газруудад үүрэг болгожээ.

## Заамар сум-нэгдлийн барилга байгууламж ашиглалтад орлоо

Октябрийн социалист их хувьсгалын 51 жилийн ойн өмнөхөн манай аймгийн Заамар суманд ЗХУ-ын хүч хөрөнгөөр тохижуулсан барилга байгууламжийг хүлээн авсан баярт үйл явдал болов.

Энд 200 хүний суудалтай клуб, номын сан, суурин кино, 8 жилийн дунд сургуулийн хичээлийн байр, дотуур байрны 2 давхар 2 барилга, мөн нэг ээлжинд 150 хүн хооллох гуанз, 30 тракторын засварын газар, 20 авто машины гараaш, 330 квт-ын цахилгаан станц, мөн уурын зуух, хоногт 1000 кг талх үйлдвэрлэх талхны газар, материал техникийн агуулах, 56 айлын 28 сууц, Ар-уртын бригадын төвд үр тарианы механикжсан агуулах 3, дарханы газар, цахилгаан станц, халуун ус, улаан булан, контор, хүүхдийн цэцэрлэг, дэлгүүр, авто пүү зэрэг барилга байгууламж сүндэрлэн босгогдсон тохилог сайхан хотхон болжээ.

Үүнээс гадна малчдын өвөлжөө хаваржаанд 129 хашаа 80 гаруй худаг гаргасан байна.

Энэ бүх барилга байгууламж нь орчин үеийн төхөөрөмжөөр иж бүрэн тоноглогдсон юм.

ЗХУ—аас Заамар нэгдэлд төрөл бүрийн маркийн авто машин 20, трактор комбайн 38, ХАА—н бусад чиргүүл машин хадлангийн иж бүрэн техник төхөөрөмж нийлүүлж өгсөн юм.

Энэ барилга байгууламжийг хүлээн авах Заамар сум-нэгдлийн хөдөлмөрчид. Зөвлөлтийн барилгачдын хамтарсан өргөн цуглаан Заамар сумын төвд болов.

Цуглааны ажиллагаанд МАХН—ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны гишүүн, БНМАУ—ын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга Д.Майдар, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга Б. Дүгэрсүрэн, ЗСБНХУ—ын Элчин Сайдын Яамны элчин зөвлөх М.И Басманов, БНМАУ—ын Нэгдлийн Холбооны Дээд Зөвлөлийн дарга Л.Ринчин, БНМАУ-ын Гадаад Явдлын Яамны нэгдүгээр орлогч сайд Д.Чимэддорж, БНМАУ—ын Сайд нарын Зөвлөлийн Гадаадтай Эдийн Засгийн талаар харилцах Улсын Хорооны дарга Д. Салдан, БНМАУ-ын Төлөвлөгөөний комиссын орлогч дарга Х. Банзрагч, Яамдын орлогч сайд Ц.Сугарragчаа, Н.Тогоо, Д. Галсан, БНМАУ-ын Нэгдлийн Холбооны Дээд Зөвлөлийн орлогч дарга С.Лувсандорж, аймгийн АДХГ Захиргааны дарга Ц. Жамсран, Намын Хорооны нарийн бичгийн дарга Д.Дамбажамц, аймгийн Нэгдлийн Зөвлөлийн дарга Ч. Дашдэмбэрэл нар оролцлоо.

Цуглаан дээр:

МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны гишүүн Д. Майдар, Заамар сум-нэгдлийн дарга Г.Халзан, Зөвлөлтийн барилгын 3 дугаар трестийн дарга А.Н. Мацуль, Заамар нэгдлийн хоньчин Сандаг, барилгачин Г.М. Юрченко, ЗХУ-ын Элчин Сайдын Яамны элчин зөвлөх М. И. Басманов нар үг хэлэв.

Цуглааны дараа: МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны гишүүн, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга Д.Майдар, Заамар нэгдэлд баригдсан 30 тракторын засварын газрын ажиллагааг нээж улаан тууз хайчлахад тэнд цугларсан зөвлөлтийн барилгачид, нэгдэлч хамт олон алга нижигнүүлэн ташиж угтав.

Дараа нь Заамарын барилга байгууламжийг хүлээн авах улсын комиссын актад гарын үсэг зурав.

Энэ актад БНМАУ-ын засгийн газрын нэрийн өмнөөс тус барилгыг ашиглалтад хүлээн авах комиссын дарга БНМАУ-ын Төлөвлөгөөний Комиссын орлогч дарга Х.Банзрагч, ЗХУ-ын засгийн газрын нэрийн өмнөөс уг барилгыг ашиглалтад хүлээлгэн өгөх улсын комиссын дарга Л. И. Максимов нар гарын үсэг зурлаа.

Гарын үсэг зурахад БНМАУ, ЗСБНХУ-ын комиссын гишүүдээс гадна БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга Д. Майдар, Б. Дүгэрсүрэн, Гадаадтай эдийн засгийн талаар харилцах улсын хорооны дарга Д.Салдан, зөвлөлтийн Элчин сайдын Яамны элчин зөвлөх М. И. Басманов болон аймгийн Намын Хорооны нарийн бичгийн дарга Дамбажамц нарын зэрэг бусад албаны хүмүүс, ЗСБНХУ-аас тус улсад суугаа Элчин Сайдын Яамны хариуцлагатай ажилтан нар байлцав.

**Манай тусгай сурвалжлагч**
**Д. Дондогдорж**